

ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2024/19/НА-СТА-ТШЗ

ТӨВ АЙМГИЙН ӨНДӨРШИРЭЭТ СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН
ТӨВИЙН 2023 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН
ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод 2024 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал
Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn
Аудитын менежер: О.Амаржаргал
Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn
Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: "Голден пэйж Аудит" ХХК
захирал: С.Оюунгэрэл

Утас: 70117179 Цахим хаяг: info@goldenpageaudit.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.open.audit.mn

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....
 - 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа
 - 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин
 - 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал
 - 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт
4. Аудитын тайлан.....
 - 4.1 Ерөнхий зүйл
 - 4.2 Материаллаг байдал
 - 4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....
 - 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал
 - 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
 - 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал
5. Аудитын илрүүлэлт
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

41100, Төв аймаг, Зуунмод сум
Утас: 70272582, Цахим шуудан: tuv@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2024-02-25 № 01/98
танай _____-ны № _____-г

ТӨВ АЙМГИЙН ӨНДӨРШИРЭЭТ
СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН
ДАРГА Б.МЯГМАРСҮРЭН ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Өндөрширээт сумын эрүүл мэндийн төвийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Өндөрширээт сумын эрүүл мэндийн төвийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангаар анхан шатны баримтаар нотлогдохгүй, 69,397.1 мянган төгрөгийн гүйлгээг баримтжуулаагүй, бараа ажил үйлчилгээ худалдан авахдаа сонгон шалгаруулалт, үнийн харьцуулалт хийгээгүй, өмнөх аудитын алдаа зөрчлийг давтан гаргасан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д; 5 дугаар зүйлийн 5.1.4-д; 20 дугаар зүйлийн 20.2.3-д; 20.2.5-д; Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д; 50 дугаар зүйлийн 50.1-д; 50.1.1-д; 50.1.2-т заасантай нийцээгүй, УСНББОУС1-д Эрх ба үүрэг, Толилуулга, Тохиолдсон байх, Иж бүрэн байх, Нийцсэн бөгөөд зохистой байх гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн “Төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга, журам шинэчлэн батлах тухай” 2023 оны 06 дугаар сарын 28-ны өдрийн 06 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар Эрүүл мэндийн даатгалын сангаас зардлын төлбөрийн хариуцах өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвөөс

019020137

үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний төлбөрийн хэмжээг тогтоосонтой холбоотой мөнгөн хөрөнгийн данс 21,496.6 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Аудитын гол асуудал

Өндөрширээт сумын эрүүл мэндийн төв нь тусгай зөвшөөрлөөр эргэлтийн эмийн сангаар дамжуулан эм худалдан борлуулах эмийн сангийн үйлчилгээг эрхлэн явуулдаг, эм борлуулсны орлого 94,148.3 мянган төгрөг цахим баримтад илүү шивэгдсэн байна.

Эргэлтийн эмийн сан нь байрны түрээсийн төлбөр, түрээсийн орлого төсөвт төвлөрүүлээгүй, төсвөөс байр ашиглалтын төлбөр, эм зүйчийн цалин хөлс, шимтгэл, гэрэл цахилгаан, дулаан, ус, хог, тээвэр, шатахууныг зарцуулж байна.

Бусад асуудлын хэсэг

Нийгмийн эрүүл мэндийн ажлын хүрээнд 3 хөтөлбөрийн хүрээнд 7 арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>192,772,031.93</u>	<u>139,667,783.34</u>
МӨНГӨН ХӨРӨНГӨ	60,702,137.05	20,076,696.44
Банкинд байгаа бэлэн мөнгө	60,702,137.05	20,076,696.44
Төгрөг	60,702,137.05	20,076,696.44
Төрийн сангийн харилцах	59,282,137.05	20,076,696.44
Арилжааны банк дахь харилцах	1,420,000.00	
АВЛАГА	454,390.10	454,390.10
Ажиллагчидтай холбогдсон авлага	453,300.00	453,300.00
Бусад авлага	1,090.10	1,090.10
Байгууллагаас авах авлага	90.10	90.10
Хувь хүмүүсээс авах авлага	1,000.00	1,000.00
БАРАА МАТЕРИАЛ	131,615,504.78	119,136,696.80
Түүхий эд материал	104,495,191.80	104,049,039.12
Тусгай зориулалттай материал	45,544,435.24	63,808,423.10
Эм боох материал	58,950,756.56	35,155,495.92
Бэлэн бүтээгдэхүүн	4,711,206.90	5,085,120.10
Хангамжийн материал	22,409,106.08	15,087,657.68
Бичиг хэргийн материал	1,032,900.00	873,600.00
Аж ахуйн материал	4,946,156.08	3,641,545.08
Сэлбэг хэрэгсэл	12,228,950.00	5,485,600.00
Түлш, шатах тослох материал	2,500.00	1,008,912.60
Хүнсний материал	1,513,600.00	1,056,000.00
Бусад хангамжийн материал	2,685,000.00	3,022,000.00
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>1,791,508,685.11</u>	<u>1,776,906,583.23</u>
ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,791,508,685.11	1,776,906,583.23
Биет хөрөнгө	1,777,314,685.11	1,762,712,583.23
Барилга, байгууламж, орон сууц	1,589,865,390.00	1,589,865,390.00
Хуримтлагдсан элэгдэл	-71,213,244.53	-103,599,882.17
Авто-тээврийн хэрэгсэл	159,575,000.00	184,375,000.00
Хуримтлагдсан элэгдэл	-53,574,999.96	-71,574,999.96
Машин тоног төхөөрөмж (компьютер)	196,043,722.97	222,246,856.06
Хуримтлагдсан элэгдэл	-85,766,245.10	-107,950,832.47
Тавилга, аж ахуйн эд хогшил	46,059,654.49	57,204,654.49
Хуримтлагдсан элэгдэл	-9,351,542.72	-12,238,552.64
Бусад үндсэн хөрөнгө	6,460,000.00	6,460,000.00
Хуримтлагдсан элэгдэл	-1,292,000.04	-2,584,000.08
Ном	508,950.00	508,950.00
Биет бус хөрөнгө	14,194,000.00	14,194,000.00
Бусад биет бус хөрөнгө	14,394,000.00	14,394,000.00

Хуримтлагдсан элэгдэл	-200,000.00	-200,000.00
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>1,984,280,717.04</u>	<u>1,916,574,366.57</u>
НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>00.00</u>	<u>14,908,680.00</u>
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	00.00	14,908,680.00
Өглөг	00.00	14,908,680.00
Бараа үйлчилгээний зардлын өглөг	00.00	14,748,880.00
Бусад өглөг	00.00	159,800.00
Байгууллагад төлөх өглөг	00.00	159,800.00
ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>1,984,280,717.04</u>	<u>1,901,665,686.57</u>
Засгийн газрын хувь оролцоо	1,984,280,717.04	1,901,665,686.57
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	218,103,311.04	218,103,311.04
Өмч: - төрийн	218,103,311.04	218,103,311.04
Хуримтлагдсан үр дүн	1,515,410,286.16	1,432,795,255.69
Өмнөх үеийн үр дүн	1,515,410,286.16	1,515,410,286.16
Тайлант үеийн үр дүн	00.00	-82,615,030.47
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	250,767,119.84	250,767,119.84
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>1,984,280,717.04</u>	<u>1,916,574,366.57</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	680,958,928.64	632,250,540.51
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	152,727,828.64	56,986,990.01
120	Нийтлэг татварын бус орлого	150,416,328.64	56,986,990.01
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	148,996,328.64	2,033,500.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	148,996,328.64	2,033,500.00
120009	Бусад орлого	1,420,000.00	00.00
122	Тусламжийн орлого	2,311,500.00	00.00
122001	Хандив тусламж /дотоод/	2,311,500.00	00.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	528,231,100.00	575,263,550.50
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	250,000.00	3,730,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	250,000.00	3,730,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	59,561,000.00	72,399,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	59,561,000.00	72,399,000.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	468,420,100.00	499,134,550.50
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	468,420,100.00	499,134,550.50
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	562,984,936.70	713,113,496.98
21	УРСГАЛ ЗАРДАЛ	562,984,936.70	713,113,496.98
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	556,492,021.24	712,889,709.81
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	270,891,747.50	361,440,729.44
210101	Үндсэн цалин	186,474,532.44	246,721,513.30

210102	Нэмэгдэл	57,749,095.38	79,396,289.48
210103	Унаа хоолны хөнгөлөлт	3,660,000.00	4,259,000.00
210104	Урамшуулал	23,008,119.68	31,063,926.66
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	36,150,678.54	45,736,355.86
210201	Тэтгэврийн даатгал	25,946,512.48	33,180,471.85
210202	Тэтгэмжийн даатгал	2,847,304.05	3,897,437.94
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,177,043.20	2,959,550.25
210204	Ажилгүйдлийн даатгал	417,364.71	518,081.45
210205	Эрүүл мэндийн даатгал	4,762,454.10	5,180,814.37
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	57,544,693.00	84,574,882.84
210301	Гэрэл, цахилгаан	7,191,241.00	10,627,602.84
210302	Түлш, халаалт	50,353,452.00	73,947,280.00
2104	Хангамж, бараа материалын зардал	39,479,257.87	37,517,899.56
210401	Бичиг хэрэг	1,945,290.00	3,557,000.00
210402	Тээвэр, шатахуун	27,186,099.87	28,426,003.20
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	551,500.00	577,500.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	560,000.00	1,771,300.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	9,236,368.00	3,186,096.36
2105	Нормативт зардал	50,061,976.74	80,389,892.14
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	41,075,986.74	69,068,422.14
210502	Хоол, хүнс	8,985,990.00	9,906,050.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	00.00	1,415,420.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	33,042,100.97	21,895,307.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	386,999.97	00.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	29,694,091.00	10,251,957.00
210604	Урсгал засвар	2,961,010.00	11,643,350.00
2107	Томилолт, зочны зардал	1,500,000.00	1,548,800.00
210702	Дотоод албан томилолт	1,500,000.00	1,548,800.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	00.00	683,608.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	400,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	00.00	242,500.00
210807	Газрын төлбөр	00.00	41,108.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	67,821,566.62	79,102,234.97
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,687,230.00	2,352,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	65,134,336.62	76,750,234.97
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	6,492,915.46	223,787.17
2132	Бусад урсгал шилжүүлэг	17,000.00	00.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	17,000.00	00.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	6,475,915.46	223,787.17
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	6,475,915.46	223,787.17
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	117,973,991.94	-80,862,956.47
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	00.00	00.00

225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	00.00	1,752,074.00
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	00.00	1,752,074.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	00.00	-1,752,074.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>117,973,991.94</u>	<u>-82,615,030.47</u>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>649,732,500.00</u>	<u>575,263,550.50</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,420,000.00	00.00
120	Нийтлэг татварын бус орлого	1,420,000.00	00.00
120009	Бусад орлого	1,420,000.00	00.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	<u>648,312,500.00</u>	<u>575,263,550.50</u>
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	120,331,400.00	3,730,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	250,000.00	3,730,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	59,561,000.00	72,399,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	59,561,000.00	72,399,000.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	468,420,100.00	499,134,550.50
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	468,420,100.00	499,134,550.50
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>566,908,428.41</u>	<u>598,803,991.11</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	<u>566,908,428.41</u>	<u>598,803,991.11</u>
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	<u>560,432,512.95</u>	<u>598,580,203.94</u>
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	271,571,248.31	361,503,863.56
210101	Үндсэн цалин	187,381,895.25	246,731,294.23
210102	Нэмэгдэл	57,521,233.38	79,171,552.98
210103	Унаа хоолны хөнгөлөлт	3,660,000.00	4,238,000.00
210104	Урамшуулал	23,008,119.68	31,363,016.35
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	36,150,678.64	45,673,221.74
210201	Тэтгэврийн даатгал	25,946,513.53	32,630,168.08
210202	Тэтгэмжийн даатгал	2,847,304.05	3,815,889.94
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,177,043.20	2,949,111.85
210204	Ажилгүйдлийн даатгал	417,364.71	566,186.55
210205	Эрүүл мэндийн даатгал	4,762,453.15	5,711,865.32
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	53,987,569.00	70,986,012.83
210301	Гэрэл, цахилгаан	6,225,014.00	15,573,300.00
210302	Түлш, халаалт	47,762,555.00	54,925,700.00
210303	Цэвэр, бохир ус	00.00	487,012.83
2104	Хангамж, бараа материалын зардал	32,325,627.00	35,912,635.80
210401	Бичиг хэрэг	2,650,800.00	3,043,700.00
210402	Тээвэр, шатахуун	26,646,329.00	30,812,835.80

210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	671,500.00	577,500.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,356,998.00	1,478,600.00
2105	Нормативт зардал	120,982,276.00	49,173,697.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	106,560,676.00	32,925,247.00
210502	Хоол, хүнс	9,455,600.00	9,448,450.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	4,966,000.00	6,800,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	38,927,884.00	23,041,400.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	10,499,200.00	4,480,000.00
210602	Тавилга	12,693,750.00	6,850,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	4,117,800.00	2,534,900.00
210604	Урсгал засвар	11,617,134.00	9,176,500.00
2107	Томилолт, зочны зардал	1,500,000.00	1,548,800.00
210702	Дотоод албан томилолт	1,500,000.00	1,548,800.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	00.00	663,652.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	400,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	00.00	242,500.00
210807	Газрын төлбөр	00.00	21,152.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	4,987,230.00	10,076,921.01
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,987,230.00	10,076,921.01
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	6,475,915.46	223,787.17
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	6,475,915.46	223,787.17
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	6,475,915.46	223,787.17
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	82,824,071.59	-23,540,440.61
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	27,700,000.00	15,665,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	27,700,000.00	15,665,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	27,700,000.00	15,665,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	27,700,000.00	15,665,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-27,700,000.00	-15,665,000.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	55,124,071.59	-39,205,440.61
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	5,578,065.46	60,702,137.05
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	60,702,137.05	21,496,696.44

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	203,909,311.04	116,128,601.07	-73,488,092.74	246,549,819.37
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	203,909,311.04	116,128,601.07	-73,488,092.74	246,549,819.37
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	9,900,312.00	9,900,312.00
C08	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	218,103,311.04	250,767,119.84	1,515,410,286.16	1,984,280,717.04
D01	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	218,103,311.04	250,767,119.84	1,515,410,286.16	1,984,280,717.04
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	218,103,311.04	250,767,119.84	1,515,410,286.16	1,984,280,717.04
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-82,615,030.47	-82,615,030.47
D09	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	218,103,311.04	250,767,119.84	1,432,795,255.69	1,901,665,686.57

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	570,456,300.00	540,289,991.11	30,166,308.89	94.71
21	УРСГАЛ ЗАРДАЛ	570,456,300.00	540,289,991.11	30,166,308.89	94.71
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	570,456,300.00	540,289,991.11	30,166,308.89	94.71
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	382,208,200.00	361,503,863.56	20,704,336.44	94.58
210101	Үндсэн цалин	248,213,300.00	246,731,294.23	1,482,005.77	99.40
210102	Нэмэгдэл	49,383,300.00	79,171,552.98	-29,788,252.98	160.32
210103	Унаа хоолны хөнгөлөлт	4,233,600.00	4,238,000.00	-4,400.00	100.10
210104	Урамшуулал	80,378,000.00	31,363,016.35	49,014,983.65	39.02
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	45,840,400.00	45,673,221.74	167,178.26	99.64
210201	Тэтгэврийн даатгал	31,172,400.00	32,630,168.08	-1,457,768.08	104.68
210202	Тэтгэмжийн даатгал	3,667,100.00	3,815,889.94	-148,789.94	104.06
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,933,800.00	2,949,111.85	-15,311.85	100.52
210204	Ажилгүйдлийн даатгал	732,000.00	566,186.55	165,813.45	77.35
210205	Эрүүл мэндийн даатгал	7,335,100.00	5,711,865.32	1,623,234.68	77.87
2104	Хангамж, бараа материалын зардал	40,695,100.00	35,912,635.80	4,782,464.20	88.25
210401	Бичиг хэрэг	3,051,600.00	3,043,700.00	7,900.00	99.74
210402	Тээвэр, шатахуун	34,381,000.00	30,812,835.80	3,568,164.20	89.62
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,762,200.00	577,500.00	1,184,700.00	32.77
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,500,300.00	1,478,600.00	21,700.00	98.55
2105	Нормативт зардал	49,203,000.00	49,173,697.00	29,303.00	99.94
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	32,949,000.00	32,925,247.00	23,753.00	99.93
210502	Хоол, хүнс	9,454,000.00	9,448,450.00	5,550.00	99.94
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	6,800,000.00	6,800,000.00	0.00	100.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	37,625,300.00	37,517,200.00	108,100.00	99.71
210601	Багаж, техник, хэрэгсэл	15,000,000.00	15,000,000.00	0.00	100.00
210602	Тавилга	12,000,000.00	11,995,000.00	5,000.00	99.96
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	2,625,300.00	2,534,900.00	90,400.00	96.56
210604	Урсгал засвар	8,000,000.00	7,987,300.00	12,700.00	99.84
2107	Томилолт, зочны зардал	1,609,200.00	1,548,800.00	60,400.00	96.25
210702	Дотоод албан томилолт	1,609,200.00	1,548,800.00	60,400.00	96.25
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,040,500.00	663,652.00	376,848.00	63.78
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	400,000.00	400,000.00	0.00	100.00
210803	Даатгалын үйлчилгээ	102,000.00	00.00	102,000.00	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	290,000.00	242,500.00	47,500.00	83.62

210807	Газрын төлбөр	25,500.00	21,152.00	4,348.00	82.95
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	223,000.00	00.00	223,000.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	12,234,600.00	8,296,921.01	3,937,678.99	67.82
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	12,234,600.00	8,296,921.01	3,937,678.99	67.82
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	511,174,200.00	372,400,572.50	138,773,627.50	72.85
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	00.00	57,337,879.00	-57,337,879.00	-
131001	Улсын төсвөөс санхүүжих	00.00	57,337,879.00	-57,337,879.00	-
1340	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	510,174,200.00	314,062,693.50	196,111,506.50	61.56
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	510,174,200.00	314,062,693.50	196,111,506.50	61.56
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	60,702,137.05	-60,702,137.05	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	21,496,696.44	-21,496,696.44	-
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	22	18	04	81.82
620001	Удирдах ажилтан	01	01	00	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	17	13	04	76.47
620003	Үйлчлэх ажилтан	04	04	00	100.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Өндөрширээт сумын эрүүл мэндийн төв нь үйл ажиллагааны эрхэм зорилгоо “Эрүүл мэндийн салбарын тогтолцооны шинэчлэлийн хүрээнд оновчтой бодлого аргагүйгээр хангаж, мэргэшсэн чадварлаг хамт олон, дэвшилтэт технологиор тусламж, үйлчилгээний чанарыг сайжруулан, амьдралын зөв дадлыг иргэн бүрд хэвшүүлэх замаар хүн амын дундаж наслалтыг уртасгана”, Эрүүл мэндийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.2-т “Сум, тосгоны эрүүл мэндийн төв”, Эмнэлгийн тусламж үйлчилгээний тухай хуулийн 6 дугаар зүйлд эрүүл мэндийн төвийн чиг үүргийг дараах байдлаар тодорхойлсон байна.

Үүнд:

- Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төв нь Эрүүл мэндийн тухай хуулийн 16.2 16.7-д заасан үндсэн чиг үүргээс гадна дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:
- Эмнэлгийн мэргэшсэн тусламж, үйлчилгээ, эх барихын тусламж, үйлчилгээ, сувилахуйн болон сэргээн засахын дагнасан тусламж, үйлчилгээ шаардлагатай иргэнийг холбогдох эрүүл мэндийн байгууллагад илгээх эргэх холбоо тогтоох, тусламж, үйлчилгээний тасралтгүй байдлыг хангах
- Харьяа нутаг дэвсгэрийн хүн амын дунд нийгмийн эрүүл мэндийг дэмжих, хамгаалах хөтөлбөр, арга хэмжээг зохион байгуулж, хэрэгжүүлэх
- Сэргээн засах, гэрээр үзүүлэх тусламж, үйлчилгээ, өдрийн эмчилгээ, оношилгоо, шинжилгээ хийх
- Түргэн тусламжийн үйлчилгээ үзүүлэх

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Өндөрширээт сумын эрүүл мэндийн төв нь Эрүүл мэндийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2-т заасанчлан “Хот суурин газрын хүн амд төрөөс үзүүлэх өрхийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг үзүүлдэг” Эрүүл мэндийн сайдын харьяа байгууллага юм.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд доорх өөрчлөлт орсон байна.

- ✓ Төсвийн тухай хууль
- ✓ Эрүүл мэндийн тухай хууль
- ✓ Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хууль
- ✓ Зөвшөөрлийн тухай хууль
- ✓ Эм, эмнэлгийн хэрэглэлийн тухай хууль
- ✓ Засгийн газрын 2023 оны 6 дугаар сарын 21-ний өдрийн 241 дүгээр тогтоолоор Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан тушаалын цалингийн доод хэмжээн
- ✓ Засгийн газрын 2023 оны 6 дугаар сарын 21-ний өдрийн 240 дүгээр тогтоолоор Төрийн үйлчилгээний албан тушаалын зэрэглэл, түүнд хамрах албан тушаалын жагсаалтад өөрчлөлт орсон.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Эрүүл мэндийн төвийн даргын 2023 оны 01 дүгээр сарын А/05 тушаалаар 4 хүний бүрэлдэхүүнтэй дотоод хяналтын баг томилогдон ажиллаж байна. Дотоод хяналтаар өгсөн үүрэг даалгаврыг биелүүлж үр нөлөөтэй ажиллаж байна.

Дотоод аудиторын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Өндөрширээт сумын эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт болон байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдлөг болгон ажиллаж байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Өндөрширээт сумын эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 53,807.5 мянган төгрөгөөр буюу 2,7 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	60,702.14	21,496.70	(39,205.44)
Авлага	454.39	454.39	-
Бараа материал	131,615.50	117,716.70	(13,898.81)
Үндсэн хөрөнгө	1,791,508.69	1,776,906.58	(14,602.10)
Нийт хөрөнгө	1,984,280.72	1,916,574.37	(67,706.35)
Өр төлбөр		14,908.68	14,908.68
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	218,103.31	218,103.31	-
Хуримтлагдсан үр дүн	1,515,410.29	1,432,795.26	(82,615.03)
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	250,767.12	250,767.12	-
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,984,280.72	1,916,574.37	(67,706.35)

Дээрх хүснэгтээс харахад нөлөө бүхий өөрчлөлт мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Мөнгөн хөрөнгийн данс 39,205.44 мянган төгрөгөөр буурсан нь урсгал зардлын дүн төлөвлөснөөс бага буюу 35,41 хувьтай зарцуулсантай холбоотой байна.

Авлагын дансны үлдэгдэл 454.39 мянган төгрөг өөрчлөлт ороогүй.

Бараа материал 13,898.8 мянган төгрөгөөр буурсан нь үлдэгдэлтэй байсан эмийн бүтээгдэхүүн зарцуулсантай холбоотой.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 14,602.10 мянган төгрөгөөр буурсан нь тайлант онд үндсэн хөрөнгөнд байгуулсан элэгдэлтэй холбоотой байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг тооцсон төлөвлөгөө, төсвийн төсөөллийг аудитад ирүүлээгүй.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд Өндөрширээт сумын иргэдийн Хурлын Төлөөлөгчдийн 2023 оны 08 дугаар сарын 14-ны өдрийн 02 дугаар тогтоолоор Эрүүл мэндийн төвийн төсвийг 72,399.0 мянган төгрөгөөр тодотгосон байна.

Тайлант оны батлагдсан төсвийг 30,166.3 мянган төгрөгөөр бууруулж зарцуулсан байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөрийн 4 арга хэмжээг санхүүжүүлэхээр 570,456.3 мянган төгрөгийг улсын төсвийн орлогоос бүрдүүлэхээр байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 540,289.9 мянган төгрөгийн санхүүжилт олгож 21,496.6 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 540,289.9 мянган төгрөг буюу 94,71 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг урамшуулалт цалин 49,014.9 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
	80302- Нэг иргэнд ноогдох нормативаар		392,423.00		

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд орлого төвлөрөөгүй.

3.5.3 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тус төсөл хэрэгжих хугацаанд нийт 3 хөтөлбөрийн 42 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа эм бэлдмэл эмнэлгийн хэрэгсэл 32,925.2 мянган төгрөг, хоол хүнс 9,448.4 мянган төгрөг, нормын хувцас зөөлөн эдлэл 6,800.0 мянган төгрөг, багаж, техник хэрэгсэл 15,000.0 мянган төгрөг, тавилга 11,995.0 мянган төгрөг, урсгал засвар 7,987.3 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардал 8,296.9 мянган төгрөг тус тус зарцуулсан байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Өндөрширээт сумын эрүүл мэндийн төвийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Голден пэйж Аудит ХХК-ийн аудитор Я.Оюун, Шинжээч Х.Ариунжаргал, Ц.Цацрал нар гүйцэтгэж, анхан шатны хяналтыг аудитын менежер, гүйцэтгэх захирал С.Оюунгэрэл хэрэгжүүлж, хяналтыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын Аудитор Ц.Саранчимэг, аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Өндөрширээт сумын эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Голден пэйж Аудит ХХК-д 2024 оны 01 дүгээр сарын 24-ны өдөр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2022 оны санхүү байдлын тайлангийн нийт хөрөнгийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны санхүү байдлын тайлангийн нийт хөрөнгийн 1,984,280.7 мянган төгрөгөөс 1,5 хувиар буюу 29,764.2 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 22,323.1 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор тус байгууллага нь бүтэц орон тоог нэмэгдүүлэхгүй байх, үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг авч ажилласнаар урамшуулалт цалин хөлсний зардлыг 29,788.2 мянган төгрөгөөр, шимтгэлийн зардал 1,621.9 мянган төгрөгөөр хэмнэн ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохислдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

1. Тайлант хугацаанд шилэн дансанд нийт мэдээлэх 159 мэдээллээс 150 мэдээллийг хугацаанд нь байршуулж, хугацаа хоцорсон 3 мэдээлэл, 6 мэдээлэл байршуулаагүй байгаа нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-д "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ" гэсэн заалтыг мөрдөн ажиллаагүй байна.

2. Шилэн дансны мэдээллээр цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын мөнгөн гүйлгээ 131,679.9 мянган төгрөгөөр зөрүүтэй, өссөн дүнгээр оруулаагүй байгаа нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.4-д “таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг”, 6.4.5-д "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр" заалтыг хэрэгжүүлэн ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1.11-д “Хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэж заасныг үндэслэн өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаж, зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

4.4.2.1 Мөнгөн хөрөнгийн түүврийн горим сорил хэрэгжүүлэхэд үйл ажиллагааны зардал, бараа түүхий эд, материал худалдан авах анхан шатны цахим баримтын бүрдэлд 94,148.3 мянган төгрөгийн цахим баримт илүү шивэгдсэн зөрүүтэй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх”, 20 дугаар зүйлийн 20.2.3-д “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах”, 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянан, баталгаажуулах” гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй, санхүүгийн оршин байх, тохиолдсон байх, үнэлгээ ба хуваарилалт, иж бүрэн байх, нийцсэн бөгөөд зохистой байх гэсэн батламж мэдэгдлүүдтэй нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төв аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар авч үзэх

4.4.2.2 Төв аймгийн эрүүл мэндийн газраас эмийн сангийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийг олгосон, Өндөрширээт сумын эрүүл мэндийн төвийн улсын бүртгэлийн гэрчилгээ дүрэмд эрхлэх үйл ажиллагаагаар бүртгэгдээгүй байгаа нь Зөвшөөрлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн нийтлэг шаардлагад 1.1-д “иргэний эрх зүйн бүрэн чадамжтай байх”, 1.2-т “хуульд заасан бол мэргэжил, мэргэшлийн шалгалтад тэнцсэн, зохих дүгнэлт гаргуулсан байх”, 1.3-д “татвар төлөгчөөр бүртгүүлсэн байх”, 2-т “Зөвшөөрөл эзэмшигч дараах үүрэг хүлээнэ”, 2.1-д “хуульд заасан баримт бичгийг үнэн зөв бүрдүүлэх”, 2.2-т “тухайн үйл ажиллагааг эрхлэх хуулиар тогтоосон нөхцөл, шаардлагыг хангаж ажиллах”, 2.3-д “хуулиар хориглосон, эсхүл хязгаарласан тохиолдолд зөвшөөрөлд зааснаас бусад үйл ажиллагаа эрхлэхгүй байх”, 2.4-д “хуульд өөрөөр заагаагүй бол зөвшөөрөлд заасан үйл ажиллагааг байнга эрхлэн явуулах”, 2.5-д “зөвшөөрлийг эрх бүхий этгээдээс авсан өдрөөс хойш 10 хоногийн дотор энэ тухай татварын албанд мэдэгдэж, татвар төлөгчийн гэрчилгээнд тэмдэглүүлэх”, 2.6-д, 3 дугаар бүлгийн 3.2.2-т заасан хуульд заасан зарчмыг баримтлах, 2.2-т заасан бүрэн эрхийн хүрээнд зөвшөөрөл олгох гэсэнтэй нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төв аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар авч үзэх

4.4.2.3 Өндөрширээт сумын эрүүл мэндийн төв нь тусгай зөвшөөрлөөр эм худалдан борлуулах эмийн сангийн үйлчилгээг давхар эрхлэн явуулдаг, эргэлтийн эмийн сан нэртэй эрхзүйн чадамжгүй, сан нь үйл ажиллагаа явуулахдаа байрны түрээсийн төлбөр төлдөггүй түрээсийн орлого төсөвт төвлөрүүлээгүй, төсвөөс байр ашиглалтын төлбөр, эмийн сангийн эм зүйчийн цалин хөлс, шимтгэл, гэрэл цахилгаан, дулаан, ус, хог, тээвэр, шатахууны төлбөрийг төлж байгаа нь Төрийн болон орон нутгийн тухай хуулийн 20 дугаар зүйлд захирлын эрх үүрэгт 20.5-д “Захирлын гэм буруутай үйл ажиллагаа болон энэ хууль, гэрээнд заасан эд хөрөнгө эзэмших эрхээ хэтрүүлэн буюу урвуулан ашиглах зэргээр тухайн үйлдвэрийн газарт хохирол учруулсан бол уг хохирлыг захирал өөрийн хувийн өмчийн эд хөрөнгөөр бүрэн хариуцна”, 21 дүгээр зүйлд “Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн хөрөнгөөр хандив тусламж, түүнтэй адилтгах аливаа

хөтөлбөр арга хэмжээ, нийгмийн шинжтэй үйл ажиллагаа, төсвийн алдагдлыг санхүүжүүлэхийг хориглоно” гэсэнтэй нийцээгүй.

Шийдвэрлэсэн нь: Төв аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар авч үзэх

4.4.2.4 Улсын бүртгэлийн гэрчилгээнд хөрөнгийн хэмжээ 38,768.7 мянган төгрөг, санхүү байдлын тайлан дээр төрийн өмч 93,803.7 мянган төгрөг засгийн газрын оролцоо сан 55,038.0 мянган төгрөгөөр зөрүүтэй байгаа Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх”; гэсэнтэй нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Мэдээллийн алдааг зөв бүртгэх зөвлөмж өгөв

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн Татварын тухай, Төсвийн тухай, Зөвшөөрлийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Улсын бүртгэлийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитаар анхан шатны и-баримтын бүрдэл, цалинтай холбоотой бүртгэл, шилэн дансны мэдээлэл, бичиг хэрэг хөтлөлт, өглөгийн данстай холбоотой бүртгэл, эмийн эргэлтийн сантай холбоотой нийт 7 зөвлөмж хүргүүлснээс 3 зөвлөмж хэрэгжүүлэн ажилласан, 4 зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар тогтоосон төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийн талаар бичнэ.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	2	1,642.2	-	-	-
Албан шаардлага	1	63,662.0	1	31,831.0	50.0
Зөвлөмж	2	1,177.8	1	-	50.0
Нийт дүн	5	66,482.00	2	31,831.0	100.0

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар нийт 66,482.0 мянган төгрөгийн 5 зөрчил илэрснээс 1,642.2 мянган төгрөгийн актыг төлж барагдуулаагүй, 63,662. мянган төгрөгийн 1 албан шаардлагын биелэлт 50,0 хувьтай хэрэгжүүлэн ажилласан, 1,177.8 мянган төгрөгийн 2 зөвлөмжийн 1 зөвлөмжийг хэрэгжүүлэн ажилласан байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Эмийн эргэлтийн сан нь байрны түрээсийн төлбөр төлдөггүй, хувь хүн иргэдэд олгосон цахим баримтыг байгууллагын регистрээр шивдэг, ашиглалтын зардал төлөхгүй байгаа асуудлыг авч үзэх, норматив зардлын гүйцэтгэлийг давтан хянах, худалдан авалт хийхдээ үнийн харьцуулалт хийдэг эсэх, албан бичгээр харилцдаг эсэхийг авч үзэх.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар илэрсэн 69,638.3 мянган төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх 69,397.1 мянган төгрөгийн 2 албан шаардлага, 241.1 мянган төгрөгийн 1 зөвлөмж, өмнөх аудитын зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаагүй санхүүгийн мэдээллийг цаг хугацаанд нь аудитад гаргаж ирүүлээгүй хариуцлага тооцуулах 1 зөрчлийг хүргүүллээ.

5.1 Хариуцлага тооцуулах тухай

- Шалгагдагч байгууллага санхүүгийн тайланг тайлагнахдаа улсын төсвийн гүйцэтгэл, нэмэлт санхүүжилтийн төсвийн гүйцэтгэлийг нэгтгэж тайлагнаагүй.
- Нэмэлт санхүүжилтийн гүйцэтгэлийг тайлагнаагүй,
- Санхүүгийн тайланд төсвийн гүйцэтгэлийн тайланг нэгтгээгүй, төсвийн тохируулгын тайланг бэлтгээгүй,
- Төсвийн гүйцэтгэлийн тайланд эмчлүүлэгчдийн тоог тайлагнаагүй.
- Өмнөх оны аудитын зөвлөмж, албан шаардлагыг хэрэгжүүлээгүй, актыг төвлөрүүлээгүй
- Аудитад санхүүгийн тайланг албан тоотоор ирүүлээгүй
- Нягтлан бодогч нь тайлант хугацаанд солигдсон, өмнөх алдаа зөрчлийг давтан гаргасан байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.3-т “Энэ хуулийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд төрийн аудитын байгууллага тухайн албан хаагчид холбогдох сахилгын шийтгэл ногдуулах, албан тушаалаас чөлөөлөх талаар эрх бүхий албан тушаалтанд албан шаардлага өгөх ба эрх бүхий албан тушаалтан ямар шийдвэр гаргасан талаараа албан шаардлагад заасан хугацаанд төрийн аудитын байгууллагад хариу мэдэгдэнэ.” гэсэн заалтыг үндэслэн албан шаардлага хүргүүлэв.

5.2 Албан шаардлага

5.2.1 Мөнгөн хөрөнгийн түүврийн горим сорил хэрэгжүүлэхэд бараа түүхий эд, материал худалдан авахдаа анхан шатны цахим баримтгүй 69,737.8 мянган төгрөгөөр дутуу хөтөлж баримтжуулаагүй, баталгаажуулаагүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, Сангийн сайдын 2017 оны 347 тоот тушаалаар батлагдсан “Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар”-ын 6.5-д Төлбөрийн баримт “Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм. Төлбөрийн баримтад борлуулагч, худалдан авагчийг таних тэмдэг, татвар төлөгчийн дугаар, төлбөр тооцоо хийгдсэн он, сар, өдөр, бараа, ажил, үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ, татварын дүнг тусгана. Төлбөрийн баримтыг цахим гарын үсэг эсхүл тусгай нууцлалын QR кодоор баталгаажуулах бөгөөд Монгол Улсын Стандарт MNS 6529:2015 “Татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага”-д заасан загварын дагуу бүртгэлийн машинаар хоёр хувь үйлдэнэ.” заалтуудыг хэрэгжүүлж ажиллах гэсэнтэй нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1.8-д “байгуулсан гэрээ, хэлцэл, холбогдох дүрэм, журмыг баримтлаагүй”; 4.2.1.11-д “Хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг

таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэж заасныг үндэслэн өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаж, зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Өглөгийн данстай холбоотой

Илрүүлэлт: Татварын цахим тайлангийн системээр Авто тээвэр, өөрөө явагч хэрэгсэл, Автын агаарын бохирдол, газрын төлбөр нийт 241.1 мянган төгрөгийн татвар төлөөгүй өглөгтэй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Тооцооллын алдаагүй, үнэн зөв бүртгэл хөтөлж байх зөвлөмж өгөв.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төв аймаг дахь Төрийн аудитын байгууллагад 2024 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Бараа түүхий эд, материал худалдан авахдаа анхан шатны цахим баримтгүй	1	69,397.1			1	69,397.1						
Авто тээвэр, өөрөө явагч хэрэгсэл, Автын агаарын бохирдол, Газрын төлбөр нийт 241.1 мянган төгрөгийн татвар төлөөгүй өглөгтэй байна.	1	241.1					1	241.1				
Тайлан хугацаанд нь ирүүлээгүй									1	1		
Дүн	3	69,638.3			1	69,397.1	1	241.1	1	1		

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Хугацаа хоцорсон 3 мэдээлэл, мэдээлээгүй 6 мэдээлэл байна.	1				1			
Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын мөнгөн гүйлгээг 131,679.9 мянган төгрөг өссөн дүнгээр зөрүүтэй мэдээлсэн байна.	1	131,679.9			1	131,679.9		
Дүн	2	131,679.9			2	131,679.9		
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Үйл ажиллагааны зарцуулалт гаргах, бараа түүхий эд, материал худалдан авахдаа анхан шатны цахим баримт 94,148.3 мянган төгрөгөөр илүү бүртгэсэн байна.	1	94,148.3					1	94,148.3
Хөрөнгийн хэмжээ 55,038.0 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан.	1	55,038.0					1	55,038.0
Эм худалдан борлуулах эмийн сангийн үйлчилгээг давхар эрхлэн явуулдаг	1						1	
Түрээсийн орлого ашиглалтын төлбөр, эмийн сангийн эм зүйчийн цалин хөлс, шимтгэл, гэрэл цахилгаан, дулаан, ус, хог, тээвэр, шатахууны төлбөрийг зориулалт бусаар зарцуулсан	1						1	
Дүн	4	149,186.3					4	149,186.3
Нийт дүн	6	280,866.2			2	131,679.9	4	149,186.3



ТӨВ АЙМАГ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 03 сарын 12 өдөр

Дугаар В-14570516-ТӨА-2024/

Зуунмод

19/НА-СТА-ТУС

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Өндөрширээт сумын эрүүл мэндийн төвийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар анхан шатны цахим баримтгүй 69,737,800 /жаран есөн сая долоон зуун гучин долоон мянга найман зуун/ төгрөгөөр дутуу хөтөлж баримтжуулаагүй зөрчил илэрлээ.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", Сангийн сайдын 2017 оны 347 тоот тушаалаар батлагдсан "Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар"-ын 6.5-д Төлбөрийн баримт "Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм. Төлбөрийн баримтад борлуулагч, худалдан авагчийг таних тэмдэг, татвар төлөгчийн дугаар, төлбөр тооцоо хийгдсэн он, сар, өдөр, бараа, ажил, үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ, татварын дүнг тусгана. Төлбөрийн баримтыг цахим гарын үсэг эсхүл тусгай нууцлалын QR кодоор баталгаажуулах бөгөөд Монгол Улсын Стандарт MNS 6529:2015 "Татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага"-д заасан загварын дагуу бүртгэлийн машинаар хоёр хувь үйлдэнэ." заалтуудыг хэрэгжүүлж ажиллах гэсэнтэй нийцээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан¹ шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.11-д "хууль, тогтоомж, гэрээ хэлэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

¹Төв аймаг, Зуунмод сум, 6 дугаар байр, Төр захиргааны 2 дугаар байр 105 тоот Утас: 70272582

019040068

1. Цахим төлбөрийн баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээ хийсэн зөрчлийг арилгаж, биелэлтийг 2024 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор Төв аймаг дахь Төрийн аудитын газарт² ирүүлэх;

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Өндөрширээт сумын эрүүл мэндийн төвийн дарга Б.Мягмарсүрэн, нягтлан бодогч У.Тэмүүжин нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

/Ц.ХИШИГЖАРГАЛ/

ГОЛДЕН ПЭЙЖ АУДИТ ХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

/С.ОЮУНГЭРЭЛ/



²Төв аймаг, Зуунмод сум, 6 дугаар байр, Төр захиргааны 2 дугаар байр 105 тоот Утас: 70272582



ТӨВ АЙМАГ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 03 сарын 15 өдөр

Дугаар Б-14510516-ТВА-2024/

Зуунмод

19/НА-СГА-ТШС

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Өндөрширээт сумын эрүүл мэндийн төвийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын мөнгөн гүйлгээг 131,679,900 /нэг зуун гучин нэгэн сая зургаан зуун далан есөн мянга есөн зуун/ төгрөг өссөн дүнгээр зөрүүтэй мэдээлсэн, хугацаа хоцорсон 3 мэдээлэл, 6 мэдээлэл байршуулаагүй зөрчил илэрлээ.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3."тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх," 6 дугаар зүйлийн 6.4-д "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ:", 6.4.4-д "таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг"; 6.4.5-д "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр;" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.11-д "хууль, тогтоомж, гэрээ хэлэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны хууль тогтоомжийг хэрэгжүүлж, мэдээллийг тогтоосон хугацаанд ил тод, бүрэн байршуулах зөрчлийг арилгаж, биелэлтийг 2024 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор Төв аймаг дахь Төрийн аудитын газарт³ ирүүлэх;

³Төв аймаг, Зуунмод сум, 6 дугаар байр, Төр захиргааны 2 дугаар байр 105 тоот Утас: 70272582

019040111

2. Цаашид алдаа⁴, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Өндөрширээт сумын эрүүл мэндийн төвийн дарга Б.Мягмарсүрэн, нягтлан бодогч У.Тэмүүжин нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

/Ц.ХИШИГЖАРГАЛ/

ГОЛДЕН ПЭЙЖ АУДИТ ХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

/С.ОЮУНГЭРЭЛ/

⁴Төв аймаг, Зуунмод сум, 6 дугаар байр, Төр захиргааны 2 дугаар байр 105 тоот Утас: 70272582



ТӨВ АЙМАГ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 05 сарын 25 өдөр

Дугаар 79-14510516-ТӨА-2024/19/НА-СТА-ТШЗ

Зуунмод

Сахилгын шийтгэл ногдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Өндөрширээт сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тус байгууллагын нягтлан бодогч нь аудитаас шаардсан санхүүгийн тайлан мэдээллийг хуулийн хугацаанд гаргаж ирүүлээгүй, удаа дараа шаардуулсан өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, зарлагын гүйлгээ хийхдээ гэрээ, анхан шатны баримтаар баримтжуулаагүй зөрчлийг давтан гаргасан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д “төсвийн шууд захирагч улирлын төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа улирлын эхний сарын 15-ны дотор гаргаж харьяалагдах дээд шатны төсвийн захирагчид, жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа оны 01 дүгээр сарын 25-ны дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж, аудит хийсэн санхүүгийн тайланг 02 дугаар сарын 25-ны дотор харьяалагдах дээд шатны төсвийн захирагчид хүргүүлэх”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журмын 19.1-д “Шалгагдагч этгээд аудитаар өгсөн зөрчил дутагдлыг арилгах..”, 19.2-т “Шалгагдагч этгээд аудитын тайланг баталгаажуулсан тушаалд заасан хугацаанд багтаан албан шаардлага, төлбөрийн акт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлтийг Төрийн аудитын байгууллагад тайлагнана” гэж тус тус заасныг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.3-т “Энэ хуулийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд төрийн аудитын байгууллага тухайн албан хаагчид холбогдох сахилгын шийтгэл ногдуулах, албан тушаалаас чөлөөлөх талаар эрх бүхий албан тушаалтанд албан шаардлага өгөх ба эрх бүхий албан тушаалтан ямар шийдвэр гаргасан талаараа албан шаардлагад заасан хугацаанд төрийн аудитын байгууллагад хариу мэдэгдэнэ”, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.2-д “Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд “Сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага” хүргүүлнэ³ гэж заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

³Төв аймаг, Зуунмод сум, 6 дугаар байр, Төр захиргааны 2 дугаар байр 105 тоот Утас: 70272582

019040299

1. Өндөрширээт сумын Эрүүл мэндийн төвийн нягтлан бодогч У.Тэмүүжин дээрх зөрчлийг гаргасан тул хуульд заасны дагуу сахилгын шийтгэл ногдуулж, биелэлтийг 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор Төв аймаг дахь Төрийн аудитын газарт⁴ ирүүлэхийг Өндөрширээт сумын Эрүүл мэндийн төвийн дарга Б.Мягмарсүрэнд даалгав.



АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

/Ц.ХИШИГЖАРГАЛ/

ГОЛДЕН ПЭЙЖ АУДИТ ХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

/С.ОЮУНГЭРЭЛ/

⁴Төв аймаг, Зуунмод сум, 6 дугаар байр, Төр захиргааны 2 дугаар байр 105 тоот Утас: 70272582